

Тав-2. Хэрэглэгчийн үнэлгээ

Сэлэнгэ аймгийн Засаг дарга, Засаг даргын
Тамгын газрын 2010 оны үйл ажиллагааны
Хяналт-шинжилгээ үнэлгээний тайлангийн
3-р хавсралт

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Асуулт	/5/		/4/		/3/		/2/		/1/		Бүгд	Дундаж үнэлгээ
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь		
1	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх таны санал дүгнэлт	101	16.1	185	29.7	298	47.7	39	6.2	2	0.3	625	3.5
2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх таны санал дүгнэлт	81	12.9	169	27	321	51.4	54	8.6	-	-	625	3.4
3	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх таны санал дүгнэлт	203	32.5	209	33.4	112	18	101	16.1	-	-	625	3.8
4	Аймгийн хэмжээнд иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний талаарх таны санал дүгнэлт	192	30.7	188	30	155	24.8	85	13.6	5	0.8	625	3.7
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ												3.6	

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙТАСАГ

Хэрэглэгчийн үнэлгээ буюу санал асуулгын нэгдсэн дүнгийн талаар:

Монгол Улсын Засгийн газрын болон нутгийн төр, захиргааны байгууллагын бодлого шийдвэрийг аймаг орон нутагтаа хэрхэн хэрэгжүүлж байгаа, иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн байдлыг судалж, үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг аймгийн “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээгээр 17 сум, 6 тосгонд 4 асуумж бүхий саналын хуудсаар судалгаа явуулж, нийгмийн бүхий л давхарга, ажил мэргэжлийн янз бүрийн бүлгийн болон ажил хөдөлмөр эрхэлдэггүй нийт 625 иргэнийг хамруулж, бүх сумдын иргэдийн төлөөллийг оролцуулан зохион байгуулснаараа илүү бодитой болсон гэж үзэж байна.

Энэ удаа хэрэглэгчийн үнэлгээг тодорхойлохдоо аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудтай хамран ажиллалаа. Санал асуулгын 1-р асуумж болох “Хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэрийн хэрэгжилт”-ийн үнэлгээнд аймгийн Үйлдвэрчний эвлэл, Ажил олгогч эздийн холбооноос зарим сумдад явуулсан Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль болон Авлигатай тэмцэх хууль, Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх судалгааны дүнг оруулан дундаж үзүүлэлтээр гаргаж тооцсон болно. Үүнд:

- Хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэрийн хэрэгжилтэнд иргэдийн 286 нь буюу 45.8 хувь нь “хангалттай сайн”, “хангалттай”, 339 нь буюу 54.2 хувь нь “дунд”, “муу” хэмээн хариулж, 3.5 үнэлгээ авсан.
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэнд иргэдийн 250 нь буюу 40 хувь нь “хангалттай сайн”, “хангалттай”, 375 нь буюу 60 хувь нь “дунд”, “муу” хэмээн хариулж, 3.4 үнэлгээ авсан.
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэнд иргэдийн **412 нь буюу 65.9 хувь нь “хангалттай сайн”, “хангалттай”,** 213 нь буюу 34.1 хувь нь “дунд”, “муу” хэмээн хариулж, 3.8 үнэлгээ авсан.
- Аймгийн хэмжээнд иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд иргэдийн **380 нь буюу 60.8 хувь нь “хангалттай сайн”, “хангалттай”,** 245 нь буюу 39.2 хувь нь “дунд”, “муу” хэмээн хариулж, 3.7 гэж үнэлэн нийлбэр дүнгээр **3.6** гэсэн үнэлгээг өгсөн байна.

Санал асуулгын дүнгээс харахад аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хувьд иргэдийн 65.9 хувь нь харьцангуй өндөр үнэлсэн нь

аймгийн Засаг даргаас явуулж буй бодлого шийдвэр, үйл ажиллагаа, үр дүнгийн талаар иргэд мэдээлэл авч чаддаг, аймгийн хэмжээнд иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд 60.8 хувь нь эерэг үнэлгээ өгсөн байгаа нь нутгийн төр захиргааны байгууллагын үйл ажиллагаа хэвийн хэмжээнд явагдаж, цаашид Засгийн газрын бодлого шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэд олон нийтэд хүргэхэд анхаарч ажиллах нь зүйтэй байна гэсэн дүгнэлтэнд хүргэлээ.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙТАСАГ